



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2023 он

АГУУЛГА

| | |
|---|-------|
| НЭГ. ТАНИЛЦУУЛГА..... | 1 |
| ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ..... | 1 |
| ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН..... | 1-14 |
| ДӨРӨВ. ДҮГНЭЛТ..... | 14-17 |
| ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ..... | 17-18 |

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ жилийн эцсийн байдлаар/

2023.12.25

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж баталсан байна.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 106 дугаар тогтоолын дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь дараах 6 тэргүүлэх чиглэл:

1. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр;
2. Бодлого төлөвлөлт, газрын харилцаа, хот байгуулалтын чиглэлээр
3. Барилга, инженерийн дэд бүтцийн чиглэлээр;
4. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр;
5. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр;
6. Салбарын хяналтын чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах зорилгоор тус хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсрууллаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь тухайн хугацааны хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, мэдээллийн үнэн, зөв байдлыг нягтлах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлсэн болно.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Барилга, хот байгуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 46 зорилтын 362 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. БХБЯ-ны ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /газар тус бүрээр/

| № | Газрууд | Зорилтын тоо | Нийт арга хэмжээ | Хэрэгжилт хувиар | | | | | | Дүн % |
|---|---------|--------------|------------------|------------------|-----|-----|-----|-----|----|-------|
| | | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | |
| | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|--|----|-----|-----|----|----|---|---|---|------|
| 1 | Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар | 4 | 89 | 71 | 7 | 8 | 3 | 0 | 0 | 95.6 |
| 2 | Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | 12 | 96 | 65 | 22 | 8 | 1 | 0 | 0 | 95.7 |
| 3 | Санхүү, хөрөнгө оруулалтын газар | 5 | 28 | 17 | 9 | 2 | 0 | 0 | 0 | 94.6 |
| 4 | Төрийн захиргааны удирдлагын газар | 10 | 45 | 39 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 96.8 |
| 5 | Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар | 11 | 71 | 48 | 20 | 3 | 0 | 0 | 0 | 95.9 |
| 6 | Салбарын хяналтын газар | 4 | 33 | 29 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 94.5 |
| | Дүн | 46 | 362 | 269 | 64 | 23 | 5 | 1 | 0 | 95.4 |

Барилга, хот байгуулалтын яамны ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт **95.4%**-ийн гүйцэтгэлтэй “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлж байна.

ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт газар тус бүрээр харуулбал:

| | Стратегийн зорилт | Зорилго | Арга хэмжээ тоо | Гүйцэтгэлийн үнэлгээ |
|---|--|---|-----------------|----------------------|
| ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 1 | Салбарын хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 1.1. Салбарт технологи, инноваци нэвтрүүлэх, олон улсад өрсөлдөж чадахуйц инженер техникийн ажилтнуудын сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. | 2 | 90 |
| 2 | | 1.2. Томоохон бүтээн байгуулалт, үндэсний, орон нутгийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг бэлтгүүлэх ажлыг зохион байгуулна. (ЗГҮАХХАХТ-2.5.10) | 3 | 96,7 |
| 3 | | 1.3. Салбарт жөндөрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн албан хаагч, инженерийн ёс зүйн чадамжийг дээшлүүлэхэд холбогдох ажлыг зохион байгуулна. | 2 | 100 |
| 4 | | 1.4. Яамны үйл ажиллагааны тогтолцоог сайжруулна. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, төрийн зарим чиг үүргийг нутгийн | 2 | 95 |

| | | | | |
|--|--|---|-----------|-------------|
| | | захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагуудаар төлөөлүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | |
| 5 | | 1.5. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, зохицуулалтаар хангаж, мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.. | 5 | 98 |
| 6 | | 1.6. Төрийн захиргааны хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана | 10 | 97.0 |
| 7 | | 1.7. Салбарын үйл ажиллагааг сурталчлах, хэвлэл мэдээллийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана. | 3 | 96.7 |
| 8 | | 1.8. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх | 2 | 100 |
| 9 | | 1.9. Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх | 9 | 100 |
| 10 | | 1.10. Салбарын гадаад хамтын ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулна. | 7 | 97.1 |
| Дундаж оноо | | | 45 | 96.8 |
| ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 11 | Монгол Улсын байгаль, орчин, нийгэм, эдийн засгийн | 2.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний нэгдсэн бодлого, төлөвлөлт, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах, салбарын норм, нормативын тогтолцоог тодорхойлох, боловсронгуй болгох. | 36 | 93.8 |
| 12 | тогтвортой хөгжлийг хангах замаар салбар дундын зохицуулалтыг | 2.2. Газрын харилцаа, газар зохион байгуулалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийн хувилбарыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих | 20 | 100 |
| 13 | хангаж, иргэдийн хууль ёсны амьдрах болон баялаг бүтээх эрхийг баталгаажуулах, | 2.3. Геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбарыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих. | 12 | 100 |
| 14 | байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий газар ашиглалтын бодлого, төлөвлөлтөөр ил тод, тэгш хүртээмжтэй, хариуцлагатай газрын харилцааг бий болгоно. | 2.4. Хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийн хувилбарыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих | 22 | 88.1 |
| Дундаж оноо | | | 89 | 95.6 |
| БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР | | | | |

| | | | | |
|---|---|---|-----------|-------------|
| 15 | | 3.1. Барилгын зураг төслийн чиглэлээр салбарын хууль тогтоомж бодлого, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах | 9 | 93.3 |
| 16 | | 3.2. Барилга байгууламжийн техникийн зохицуулалтын баримт бичиг, барилгын норм, нормативын баримт бичиг боловсруулж, батлуулах | 7 | 92.9 |
| 17 | | 3.3.Барилгын салбарын үйл ажиллагааны удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах | 2 | 100 |
| 18 | Барилга, барилгын материалын үйлдвэрийн хууль тогтоомж, эрх зүйн болон норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх | 3.4. Газар хөдлөлийн чиглэлээр салбарын холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангах, газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах | 8 | 90 |
| 19 | | 3.5. “Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | 5 | 100 |
| 20 | | 3.6. “Барилгын материалын чанар, аюулгүй байдлыг хангах”, “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц хөтөлбөр”-ийн 2.18, “Монгол экспорт хөтөлбөр” ХАХТ-1.2.3-ийн хэрэгжилтийг хангах. | 5 | 100 |
| 21 | | 3.7. Барилгын материалын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангуулах | 4 | 95 |
| 22 | | 3.8. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах | 1 | 100 |
| 23 | Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх | 3.9. Инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний салбар хоорондын төлөвлөлтийг уялдуулж, нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллана. | 9 | 92.2 |
| 24 | | 3.10. Инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх замаар дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна | 22 | 90.5 |
| 25 | Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын санхүүгийн чадавх, бие даасан байдлыг бэхжүүлэх. | 3.11 Салбарын байгууллагуудын санхүүгийн чадавх, бие даасан байдлыг бэхжүүлэхэд олон улсын донор байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллана | 8 | 97.5 |
| 26 | | 3.12. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх | 16 | 96.3 |
| Дундаж оноо | | | 96 | 95,7 |
| САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 27 | Санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | 4.1.Салбарын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ. | 5 | 92 |
| 28 | | 4.2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах | 4 | 95 |
| 29 | | 4.3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах | 4 | 95 |

| | | | | |
|--|--|---|-----------|-------------|
| 30 | | 4.4. ТЭЗҮ, зураг төсвийн нэгдсэн цахим мэдээллийн сан, архивын бааз бүрдүүлэх | 1 | 90 |
| 31 | | 4.5. Салбарын эдийн засгийн бодлогыг боловсруулах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх | 15 | 90 |
| Дундаж оноо | | | 28 | 94.6 |
| ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 32 | Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах | 5.1.Бодлогын баримт бичигт тусгагдсан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | 9 | 98.9 |
| 33 | | 5.2.Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах | 2 | 100 |
| 34 | | 5.3 Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуйн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | 2 | 95 |
| 34 | | 5.4 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах | 8 | 98.8 |
| 36 | | 5.5 Яам, агентлаг, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах | 19 | 97.4 |
| 37 | | 5.6 Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах | 5 | 90 |
| 38 | | 5.7 “Төсвийн тухай хууль” хуулийн хүрээнд Салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, яамны удирдлагад тайлагнах | 6 | 100 |
| 39 | Салбарын статистик, суурь судалгааг боловсруулах, | 5.8. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангана. | 4 | 90 |
| 40 | хөгжүүлэх, мэдээлэл, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг идэвхжүүлэх, | 5.9. Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | 7 | 88.6 |
| 41 | хүртээмжийг нэмэгдүүлэх | 5.10. Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана. | 4 | 100 |

| | | | | |
|------------------------------------|--|--|------------|-------------|
| 42 | | 5.11. Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулж, Салбарын статистикийн мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулж өгөгдлийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана. | 5 | 96 |
| Дундаж оноо | | | 71 | 95.9 |
| САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 43 | Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүл | 6.1. Салбарын хяналтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн ангиллыг тогтоох, эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгох ажлыг нэгдсэн арга зүй, зохион байгуулалтаар хангана | 9 | 100 |
| 44 | | 6.2. Салбарын хяналт шалгалтын цахим системүүдийг хөгжүүлж, нэгдсэн удирдлагын системтэй болно | 2 | 30 |
| 45 | | 6.3. Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ | 13 | 97.7 |
| 46 | Салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтууд зохион байгуулж, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх | 6.4. Салбарын хяналтын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. | 9 | 96.7 |
| | | | 33 | 94.5 |
| 46 | НИЙТ ОНОО | | 362 | 95,5 |

Барилга, хот байгуулалтын яам нь 2023 оны жилийн эцсийн байдлаар дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр:

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах барилга, хот байгуулалтын салбарт авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, яамны 2023.01.13-ний өдрийн 1/138, 2023.04.24-ны 1/1440 тоот албан бичгүүдээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

2. Монгол Улсад ногоон, тогтвортой барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай хамтран ажиллах Санамж бичгийг 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулж ТНБД С.Магнайсүрэн гарын үсэг зурж баталгаажуулав. Санамж бичгийн хүрээнд ногоон барилга, ногоон технологийг танилцуулах, сурталчлах, салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх чиглэлээр сургалт зохион байгуулах эрхийг тус холбоонд шилжүүлэх гэрээний төслийг боловсруулж батлуулсан.

3. “Ногоон барилгын тогтолцоог бүрдүүлэх судалгаа”-ний Техникийн даалгаврыг ТНБД-аар 2023.04.05-ны өдөр №09/2023 дугаартай батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Зөвлөх үйлчилгээний тендерийг 2023.05.18-ны өдөр Худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан “Монголын Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 2023/171 тоот гэрээ байгуулсан. Үйл ажиллагааны эхний шатны тайлан ирүүлсэн. Ногоон

барилгын үнэлгээний Үндэсний системийг бүрдүүлэхээр BestGER системийн танилцуулга, хэлэлцүүлгийг 2023.12.13-ний өдөр хийсэн;

4. 2023 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн цахим систем <https://norm.nextgis.mn/> системийн хөгжүүлэлт 100 хувьтай болж гүйцэтгэл хянуулахаар “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 1/2438 тоот албан бичгээр ирүүлснийг 2023.09.06-ний 3/3215 тоот албан бичгээр эрх олгосон. Одоо холбогдох системийн тохируулга хийгээд Дэд сайдад танилцуулан эцэслэн хүлээн авахад бэлэн болсон.

5. 2023 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар арилжааны банкнуудад нийт 2,009.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 799.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 7,665 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 69.1 хувь буюу 552.5 тэрбум төгрөгийн 4,605 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 30.9 хувь буюу 246.7 тэрбум төгрөгийн 3,060 зээлийг орон нутагт олгосон байна. Мөн тус хугацаанд гарсан 799.2 тэрбум төгрөгийн зээлийн 640.2 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 159.0 тэрбум төгрөг нь арилжааны банкнуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжсэн байна.

6. Орхоны хөндийд “Шинэ Хархорум хот байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаан, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж улмаар УИХ-ын 2023.01.19-ний өдрийн 07 дугаар тогтоол гарсан. Үндэсний хорооны 2023.04.15-ны өдөр зохион байгуулагдсан 2-р хурлаар төслийн хүрээнд хийгдсэн ТЭЗҮ хэлэлцэж Шинэ Хархорум хот байгуулах 189 363 га газрын байршлын асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлэсэн.

Барилга, инженерийн дэд бүтцийн чиглэлээр:

1. Барилга, хот байгуулалтын яамнаас захиалан боловсруулж батлуулсан “Эрүүл мэндийн төвийн барилгын нэг маягийн зураг төсөл /15 ортой/”-ийг Завхан аймгийн Тэс суманд холбож 2023-09-05-ны өдрийн ЕД-1406/2023, Завхан аймгийн Цэцэн-Уул суманд холбож 2023-08-15 -ны өдрийн ЕД-1245/2023 тус тус магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөл /Төв/-ийн боловсруулалт бүрэн дуусаж 1280/2023 дугаар магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан.

2. Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт төлөвлөн, баригдах “President” спорт цогцолборын барилгыг иж бүрэн ажлын зураг төсөл магадлал хийлгэхээр экспертүүдийг томилон ажиллаж байна. Ажлын зураг дуусаж, БНХАУ-ын элчин сайдын яаманд 2023.09.24-ний өдөр хүргүүлсэн.

3. БХБС-ын 2019 оны 54 дүгээр тушаалаар батлагдсан журмын хүрээнд “Барилга байгууламжийн нэг маягийн зураг төсөл болон давтан хэрэглэх зураг төслийн мэдээллийн систем хөгжүүлж, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-ыг боловсруулан батлуулж, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч “Интерактив” ХХК ажиллаж байна.

Барилгын нэгдсэн мэдээллийн систем <https://mcis.gov.mn/mn> -ийн “норм норматив” цэсэд шинээр “зураг төсөл” гэсэн мэдээллийн санг үүсгэж 2023 оны 12 дугаар сарын байдлаар 2021-2023 онд хийгдсэн нийт 30 нэг маягийн зураг төслийг оруулаад байна.

4. Баруун бүсийн Ховд аймагт “Вестерн Холд” ХХК-ийн жилд 250 мянган тонн цемент үйлдвэрлэх үйлдвэр 2023 оны 1 дүгээр сард ашиглалтад орсон.

5. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтод баригдах барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн барилгын ажил дуусаж 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр комисс ажиллаж, хүлээн авсан

6. 2023 оны 01 дүгээр сараас 2023.11.30-ны өдрийн байдлаар 46 удаагийн баталгаажуулалтаар БҮАТЗ хүссэн нийт-1540 ААНБ-ын өргөдөл материал хянагдаж, баталгаажуулалт хийв. Үүнээс сунгалтаар-249, шинээр-912, нэмэлтээр-361, дахин олголтоор-18 ААНБ-д БҮАТЗ олгов. Сунгалтаар-249 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар-200, Зураг төсөл боловсруулахаар-39, өргөх байгууламжаар-10, Шинээр-912 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар-732, Зураг төсөл боловсруулахаар-146, өргөх байгууламжаар-34, Нэмэлтээр-361 ААНБ-д БҮАТЗ-ийн ажилбар нэмж олгосноос: Барилга угсралтаар-258, Зураг төсөл боловсруулахаар-101, өргөх байгууламжаар-34 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан байна. Дахин олголтоор-18 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар-12, Зураг төсөл боловсруулахаар-5, өргөх байгууламжаар-1 ААНБ-д БҮАТЗ-ийн гэрчилгээг дахин олгов. "МБМҮХ" ТББ-аас ирүүлсэн 25 удаагийн нийт 446 ААНБ-ын өргөдөл материал хянагдаж, баталгаажуулалт хийснээс, шинээр-115, сунгалтаар-9, дахин олголтоор 2 аж ахуй нэгжийн хүсэлтийг Сайдын тушаалаар баталгаажуулан хүргүүлсэн.

7. Инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгч "Хангилцаг" ХХК, "Эм Даблю Ти" ХХК-ийн түншлэл захиалагчтай 8,145.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2022 оны 10-р сард байгуулсан. Одоогийн байдлаар 4000ш хавтан үйлдвэрлэсэн. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн хамт 2023.09.19, 2023.11.01-ний өдөр ажлын явцтай танилцаж, эрчимжүүлэх чиглэл өгч ажилласан. Нийт 4.9 км үерийн хамгаалалтын суваг хийгдэхээс 2.7 км сувгийн ухлага, 2.5 км сувгийн барилга угсралтын ажил хийгдсэн. Энэ онд санхүүжих төсөвт өртөгт хийгдэх ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэл 100%.

8. "Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө"-г боловсруулах ажлын даалгаварт заасны дагуу БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2023.04.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. НИТХ-ын 2023.06.21-ний 65 дугаар тогтоолоор батлагдсан. Сайдын зөвлөлийн 2023.06.28-ны 4-р хурлаар дэмжиж, 2023.09.06-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Улаанбаатар хот болон дагуул хаяа хот тосгодын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөтэй болсон байна.

9. Улаанбаатар хотод нийт 4.2 км үерийн хамгаалалтын далан, суваг баригдсан үе шатны ажлууд үргэлжилж байна. Орон нутгийн хэмжээнд 29 км үерийн хамгаалалтын байгууламж баригдсан.

10. Дархан-Уул аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дуусаж, 2023 оны 12 сарын 1-ний өдөр техникийн комисс, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж хүлээн авсан.

11. Төслийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл 100%, бараа материалын татан авалт 80%, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 70%, төслийн технологийн 55 байгууламжаас барилга байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай байна.

12. Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвд хэрэгжиж, төслийн эцсийн тайланг БХБЯ-ны 2023.04.07-ны өдрийн 3/1200 тоот албан бичгээр Сангийн яам, АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлсэн. Цахимаар Сангийн яамны Гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /odamis.mof.gov.mn/-д байршуулсан. Төсөл бүрэн хэрэгжиж дууссан.

13. "Барилга байгууламжийн Чанарын Улсын форум-2023"-ыг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордны их танхимд зохион байгууллаа. Тус Форумгаас 3 бүлгийн

25 зөвлөмжийг баталсан ба зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Мөн дараах зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

- “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, аюулгүй байдал” 2023.05.15-ны өдөр;
- “Барилга байгууламжийн зураг төслийн чанар, аюулгүй байдал” 2023.05.24-ний өдөр;
- “Барилгын чанар, аюулгүй байдал-паспортжуулалт” 2023.06.02-ны өдөр;
- “Барилгын материалын үйлдвэрлэл, импортын бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал” 2023.06.09-ний өдөр.

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

1. Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2024 оны төсвийг батлуулсан.
2. Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан 384,7 тэрбум төгрөгийн төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг холбогдох хэлтэстэй хамтран боловсруулж, Сангийн яаманд санал хүргүүлсэн бөгөөд батлагдан ирсэн хуваарийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн төсвийн тодотголоор батлагдсан 392,4 тэрбум төгрөгийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг батлуулан харьяа байгууллагуудад хүргүүлсэн.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2023 онд шилжин хэрэгжиж дуусах нийт 416,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 182,5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 126 төсөл арга хэмжээнээс 2023 он жилийн эцсийн байдлаар 380.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 173.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 118 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсвийн ажлуудаас 2023 онд шилжин хэрэгжих нийт 22,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 64 төсөл, арга хэмжээнээс 19,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8,0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 57 төсөл, арга хэмжээний бүрэн дуусаад байна.
5. Барилга, хот байгуулалтын салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар дараах төслүүдийн хүрээнд 93 гүйлгээний нийт 109,109.99 сая төгрөгийн санхүүжилтийг шилэн дансны системд тухай бүр оруулсныг хянаж, Сангийн яаманд хүргүүлсэн.
6. Шилэн дансны тухай хуулийн дагуу тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан, гэрээний мэдээлэл болон холбогдох файлууд бүхий 72 мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр байршуулж ажилласан.
7. Яамны 93 албан хаагчийн цалинд нийт 2,569.85 сая төгрөг зарцуулснаас гарт олгосон 1,326.98 сая, ХХОАТ 220 сая, НДШ-ийн суутгал 658.7 сая тус тус байна. Нийгмийн даатгалын НД-7, НД-8 тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор, ХХОАТ-ын ТТ-11 тайланг улирал бүр хүргүүлж ажиллаж байна.

Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр:

1. 2023 оны сургалтын хөтөлбөр, шалгалтын төлөвлөгөөг батлуулан, ТББ, мэргэжлийн байгууллагуудад хэрэгжүүлэх чиглэлийн хамт хүргүүлсэн. ТНБД-ын 2023.4.19-ны А/17, 2023.6.22-ны А/33, 2023.12.04-ны А/68 дугаар тушаалаар нийт 1,061 мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, 746 мэргэжилтний мэргэшлийн зэргийг сунгах асуудлыг тус тус шийдвэрлүүлсэн.

2. Төрийн нарийн бичгийн даргын 2023 .05.08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар БХБЯ-ны дэргэдэх Төрийн албан хаагчийн орон тооны бус Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн батлуулсан. Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ зохицуулах хороо, ТОСК-д Ёс зүйн зөвлөл байгуулж ажиллах чиглэлийг яамнаас хүргүүлснээр БХТ Ёс зүйн зөвлөлөө байгуулж, яаманд ирүүлсэн.

3. Яамны үйл ажиллагаанд “Чанарын “Чанарын менежментийн тогтолцооны стандарт ISO 9001:2015”-ыг нэвтрүүлг Баталгаажуулалтын Гэрчилгээг 2023.12.15-ны өдөр гардан авсан.

4. Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа, төслийн нэгжийн албан хаагчдын томилгооны асуудлыг нягтлан шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийг Барилга хот байгуулалтын сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр баталж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өгсний дагуу хяналт, шалгалтыг 4 багт хуваагдан, төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан.

5. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан байна. Мөн Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдад зориулсан 4 дэх өдөр бүр зохион байгуулагдаж буй 7:4:10 16 удаагийн сургалтад яам болон агентлагийн давхардсан тоогоор 627 албан хаагчийг хамруулсан.

6. Барилга, хот байгуулалтын яам, албан тушаалтанд иргэдээс 2023.01.01-ний өдрөөс 2023.08.30-ны өдөр хүртэл хугацаанд бичгээр 115 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Үүнээс хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн 96, хугацаа хэтэрсэн 3, судлагдах шатандаа 16 өргөдөл, гомдол байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 93,2% -тай байна гэж дүгнэсэн. Мөн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан тус яаманд 335 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнээс 68,4%-ийг нь шийдвэрлэсэн, 31%-ийг харьяалах байгууллагад шилжүүлсэн, 7 өргөдөл судлагдах шатандаа байна. Үүнээс 3 өргөдлийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах Хороонд харьяаллын дагуу шилжүүлж, 4 өргөдөл шийдвэрлэх шатандаа, 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц 99,4% -тай байна гэж дүгнэсэн.

7. Сайдын 2023.01. 20-ны 13 дугаар тушаалаар Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 хүнтэйгээр шинэчлэн батлуулсан. Сайдын зөвлөл 01.20, 02.27, 06.13, 06.28-ны өдрүүдэд хуралдаж нийт 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан хуваарийн дагуу 21 удаа хуралдсан.

8. Салбарын хэмжээнд нийт **35** хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч, арга хэмжээ, үйл явдал, мэдээ мэдээлэл, ажлын байрны сонгон шалгаруулалт, эмгэнэл, мэндчилгээ, зарлал зэргийг түгээж ажиллалаа. Яамны цахим хуудасны дагагчдын тоо оны эхэнд нэгдүгээр сард **28.349** байсан бол хагас жилийн тайлант хугацааны үеэр **30.320** болж, **1,971** хүнээр дагагчдын тоо өссөн үзүүлэлттэй гарлаа. Яамны пээж хуудасны нийт хандалтын тоо **290.000** хүнд хүрсэн үзүүлэлттэй байна. БХБЯ-наас 2023 онд жилд нийт **6** удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав.

9. 2023.09.21-ний өдөр БХБУА-ны Шуурхай штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал сэдвээр цагийн байдал өгч улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон хүч хэрэгсэл, холбоо зохион

байгуулалтыг хэрхэн зохион байгуулж байгааг хянаж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч ажиллах хүрээнд 2 дугаар үзлэгийг ОБЕГ-аас зохион байгуулсан бөгөөд ОБЕГ-аас Барилга, хот байгуулалтын улсын алба нь үзлэгийн үйл ажиллагаанд бэлтгэл сайн хангаж идэвх санаачилга, зохион байгуулалттай байгааг үнэлсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:

1. Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан 2023 оны 12 дугаар сарын 28-ны 1/4881 тоотойр ЭЗХЯ-нд хүргүүлсэн

2. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2023 онд хэрэгжүүлэх 69 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2023.06.28-ний өдөр БХБЯСайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж тайланг 2023 оны 06 дугаар 28-ний өдрийн 1/2388 албан тоотойр ЗГХЭГ-т хүргүүлж, жилийн эцсийн байдлаарх хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан, 2023 оны 12-р сарын 28-ны 1/4876 тоотойр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

3. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023.06.13-ны өдөр БХБСайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж тайланг 2023.06.14-ний өдрийн 2/2188 албан тоотойр ЭЗХЯ-нд хүргүүлж, ЗГХШҮМЦС-д байршуулсан. Жилийн эцсийн байдлаарх хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан, 2023 оны 12 дугаар сарын 28-ны 1/4881 тоотойр ЭЗХЯ-нд хүргүүлсэ

4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2023 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 1/4813 тоотойр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

5. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 7 төслийн нэгжийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт, яамны дотоод 3 газар, харьяа 3 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гарган хүргүүлсэн.

6. Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”ны бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 180 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Дотоод аудитын хороо нь 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хуралдан Дотоод аудитын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Дотоод аудитын хороо нь төлөвлөгөөний дагуу дотоод аудитын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
- “Барилга хөгжлийн төв” ТӨААТҮГ
- “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн нэгж
- “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл-МОНГ3244”-ийн төсөл
- Ногоон нуур-1008 айлын орон сууц төсөл”
- БНПольш Улсын нөхцөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Аймгуудын бохир ус цэвэршүүлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”

7. Тусгай зөвшөөрлийн цахим систем /www.mcis.gov.mn/-ээр дамжуулан 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 9930 хүсэлтийг хүлээн авч, 2141 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон ба уг системийн үндсэн сервер “Үндэсний дата төв” УТҮГ-д байрлаж, Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем, Танилт нэвтрэлтийн ДАН системүүдтэй холбогдон ажиллаж байна. Цахим системээр олгосон тусгай зөвшөөрлийн 97.5 хувийг МБҮА, 2.5 хувийг МБМҮХ, ГЗБГЗЗГ-ууд хянаж, олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

8. Хүлэмжийн хийн тооллогын цахим систем <http://ghgconstruction.gov.mn> -ийг сайжруулах, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, тус байгууллагын санхүүжилтээр уг системийг сайжруулж, хөгжүүлэх ажлууд дээр хамтран ажилласан.

9. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 5.3 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр батлуулан, нээлттэй өгөгдлийн хэрэгжилтийн тайланг гарган Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 03 дугаар 22-ны өдрийн 1/950 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын дагуу өгөгдлийг хөрвүүлэн төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд тогтмол шинэчлэн нийтэлж байна.

Салбарын хяналтын чиглэлээр

1. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журмын төслийг шинэчилж боловсруулж БХБСайдын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 259 дугаартай тушаалаар 9 бүлэг, 52 заалттай бүхий “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг батлуулсан.

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг Барилгын техник, цахилгаан, дулаан, өргөх механизм, газар, геодези, зураг зүйн хяналтын 6 чиглэлээр боловсруулсан. 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

3. Өргөх байгууламж, зуух, даралтат савны ашиглалтын байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай 2023.03.01-ний өдрийн 02-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 13 аж ахуйн нэгж байгууллагын 6 зуух, 65 даралтат саванд техникийн магадлал хийж, 1695 өргөх байгууламжийг улсын бүртгэлд бүртгэж ашиглах зөвшөөрөл олгосон. Тайлант хугацаанд Лифт 388, эскалатор 22, кран 301, сагстай өргөгч 83, барилгын өргүүр 596, манипулятор кран 280, бетон шахуурга 25 буюу 1695 өргөх байгууламжийг улсын бүртгэлд бүртгэж ашиглах зөвшөөрөл олгож ажилласан байна.

4. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран “Өргөх байгууламжийн чанар, аюулгүй байдал, стандарт” сэдэвт зөвлөгөөнийг 2023.04.04-ний өдөр ХНХЯ, СХЗГ, ХСХГ, Барилгын ассоциаци, Өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагын 145 албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, Зөвлөгөөнөөс гарсан техникийн ашиглалт, аюулгүй байдлын талаарх зөвлөмжийг оролцсон 88 байгууллагын албан хаагчдад өгсөн.

5. Аймаг, Нийслэлийн хэмжээнд "Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяны хүрээнд ХСХГ, ГХБХБГ, ХХҮГ -ууд хамтран барилгын талбай дээрх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр 46 удаагийн танхимын сургалтыг тусгай зөвшөөрөл бүхий 994 нэгж байгууллага, 34 удаагийн үзүүлэх сургалтыг

644 тусгай зөвшөөрөл бүхий нэгж байгууллагуудыг оролцуулан тус тус зохион байгуулсан байна.

6. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 10 удаагийн 46 объектын улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан, илэрсэн дутагдлыг арилгуулах үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулж байнгын ашиглалтад оруулсан байна.

Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан, жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “хангалтгүй” 30-50%-тай үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. 6.2.1 Салбарын хяналт шалгалтын цахим системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.1.34. Богдхан уулын Их тэнгэрийн аманд байрлаж буй Их тэнгэр цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна. ЗГ-ын 2022 оны 299 дугаар тогтоолоор маш нууцад хамруулсан.
2. 2.4.6. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8.1.2, 8.1.3 дахь заалтууд
3. 2.4.20. Вебд суурилсан зураглалын платформд “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ)”-ийн мэдээллийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. МУЗГҮАХХАХТ- 2.3.9.1
4. 3.10.10. Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулах.
5. 6.2.2. Хариуцсан салбарын хүрээний төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох саналыг тавьж шийдвэрлүүлэх.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Барилга, хот байгуулалтын яамны ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан нийт 46 зорилтын 362 арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үнэлгээ **95,5** хувьтай **"тодорхой үр дүнд хүрсэн"** байна.

Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь жилийн эцсийн байдлаар дараах бүтцийн хүрээнд төлөвлөгдсөн байна. Үүнд:

Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалт чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ 25 хувийг, Барилга, инженерийн дэд бүтцийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 26 хувийг, Санхүү, хөрөнгө оруулалт төлөвлөлтийн чиглэлээр 8 хувийг, Төрийн захиргаа, удирдлагын чиглэлээр 12 хувийг, Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ 20 хувийг, салбарын хяналтын чиглэлээр 9 хувийг тус тус эзэлж байна.

БХБЯ-ны ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жилийн эцсийн байдлаар тусгагдсан арга хэмжээ чиглэл тус бүрээр /эзлэх хувиар/



Монгол Улсын барилгын салбарын статистик, тоон мэдээлэл 2023 оны 3 дугаар улирлын байдлаар:

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2023 оны эхний 9 сард 5.6 их наяд төгрөг болж, 5.4 (96.4%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 203.6 (3.6%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна. Барилга угсралт, их засварын ажил 2023 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 973.3 (21.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 893.5 (19.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2023 оны эхний 9 сард оны үнээр 46.5 их наяд төгрөгт хүрсний 918.9 (1.9%) тэрбум төгрөгийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2016 оны мөн үеэс 376.6 (69.4%), 2020 оны мөн үеэс 258.6 (39.1%), өмнөх оны мөн үеэс 153.9 (20.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 918.9 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 400.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.0 (2.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ажиллах хүчний судалгааны 2023 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд Барилгын салбарт 89.4 мянган ажиллагчид ажиллаж байна. Үүнээс: Улаанбаатар хотод 63.4 (70.9%), баруун бүс 10.9 (12.2%), хангайн бүс 8.8 (9.9%), төвийн бүс 5.8 (6.5%), зүүн бүс 0.3 (0.3%) мянган ажиллагчид тус тус ажиллаж байна. Барилгын салбарын нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 1876.2 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 388.2 (26.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 95.1 (5.3%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

2023 оны ажлын үр дүн:

➤ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2008 оноос хойш гаргасан нийт **8437** барилга байгууламжийн дүгнэлтийг Улсын хэмжээнд нэгтгэж, шилэн систем /shilen.gov.mn/-д байршуулсан.

➤ Барилга хот байгуулалтын сайдын 45 дугаар тушаалаар Арматур худалдан борлуулж буй 16 аж ахуйн нэгж байгууллагын импортын болон дотоодын арматур лабораторийн болон газар дээрх жин тонны шалгалт хийлээ. Шалгалтаар тонн, жингийн хүлцэх алдааг хангаагүй, чанарын шаардлага хангахгүй арматур үйлдвэрлэсэн, тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгж байгууллагуудад зөрчлийн хэрэг

үүсгэн, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч, шаардлага хангахгүй 360 тонн арматурыг лацдаж, дахин боловсруулах чиглэл өгсөн.

➤ Салбарын “Цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөө”-г Барилга, хот байгуулалтын сайдын 92 дугаар тушаалаар батлуулж, 2023 оны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

➤ Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын онлайн платформ (<http://ghgconstruction.gov.mn>) буюу тооллогын мэдээллийн системээс төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээнд холбогдоогүй, ердийн галлагаатай барилга байгууламжаас ялгарч буй Хүлэмжийн хийн тооцоог сар, улирал бүрээр хийж эхэлсэн.

➤ Салбарын Шинжлэх ухаан, техник технологийн цахим систем <https://norm.nextgis.mn/>-ийг хэрэглээнд нэвтрүүлж, мөрдөж буй норм нормативын цахим санг бий болж, боловсруулалтын үе шат бүрд орсон өөрчлөлт, засваруудыг хадгалах, харьцуулалт хийх, нийтэд түгээх, байгууллага, иргэдээс санал авах, оролцоог хангах, тусгасан саналыг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг баримт бичгийн боловсруулалттай холбоотой бүх үе шатыг цахимаар явуулах боломж бүрдүүлсэн.

➤ Улсын хэмжээнд 21279 барилга байгууламж, 34 барилгын материалын үйлдвэр, 300.91 км үерийн хамгаалалтын байгууламжийн зураг төслийн боловсруулалт, угсралтын чанар, ашиглалтын төлөв байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, 306 улсын байцаагчийн шийдвэр, 506 зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулаа. Улсын байцаагчдын гаргасан дүгнэлтийг үндэслэн 11 барилгыг буулгаж, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, дотуур байр, соёлын төвийн 10 барилга, орон сууцны 14 барилгыг шинээр бариулж, нийтийн орон сууцны 18 барилгын төлөв байдлыг тогтоон паспортжуулж, цэцэрлэг, орон сууцны 47 барилгын гадна ханыг хүчитгэж, нийт 1611 барилгад засвар хийлгүүлсэн.

➤ “Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг Засгийн газрын 97 дугаар тогтоолоор, “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг Засгийн газрын 98 дугаар тогтоолоор батлуулж, барилга байгууламж, тэдгээртэй холбоотой зураг төслийн баримт бичиг боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, хамгаалалтад авах зэрэг барилгын бүх техникийн үйл ажиллагааг зохицуулж, нийтээр дагаж мөрдөх зохицуулалтыг бий болгосон.

➤ Зэх зээл дээрх орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн бодит статистик, Түрээсийн орон сууцны хүсэлт авах, хянан шийдвэрлэх үе шат, үл хөдлөх хөрөнгийн контент зэрэг үйлчилгээг олон нийтэд хүргэх нэгдсэн порталыг хөгжүүлж, [/www.oronsuuts.mncud.gov.mn/](http://www.oronsuuts.mncud.gov.mn/) цахим системийг ашиглалтад оруулсан.

➤ Улсын бүртгэлд 20000 гаруй өргөх байгууламжийн бүртгэл мэдээллийн баазыг үүсгэж, Барилгын хөгжлийн төв, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран “UB engineering” мэдээллийн санд 2704 лифтний мэдээлэл, АТҮТ-тэй хамтран тээврийн хэрэгсэлд тоноглогдсон өргөх байгууламжуудын цахим мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн ажилласан байна.

➤ Цамхагт краны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээний хүрээнд 284 барилгын кранд техникийн аюулгүй байдлын шалгалт хийж, эрсдэлтэй олон жил ашиглагдаагүй 5 краныг технологийн горимын дагуу буулгаж, техникийн зөрчилтэй 12 краны үйл ажиллагааг зогсоон битүүмжилж, хугацаа дууссан нийт 125 цамхагт краныг буулгуулсан.

➤ Барилгын зураг төсөл боловсруулагчид, барилга угсралтынхан, материал үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчид, төсөвчид, гүйцэтгэгч нар, тусгай зөвшөөрөл олгогч ТББ-ууд гээд салбарын бүх талын оролцогчдын үйл ажиллагааг нэгтгэсэн цахим сүлжээ “BIM” нэвтрүүлэх хүрээнд “ROAD MAP” боловсруулж, хууль эрх зүйн баримт бичгийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна.

➤ Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтод байрлах “Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори”-ийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан.

➤ Онцгой байдлын Ерөнхий газраас Барилга, хот байгуулалтын Улсын албаны Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, төлөвлөгөөг хэрэгжүүлж буй байдал, техник хэрэгслийн нөөц, хүч нэмэгдүүлэлт, холбоо мэдээллийн үйл ажиллагаанд Улсын үзлэг явуулаа. “БАРИЛГЫН САЛБАР ГАМШГИЙН ЭСРЭГ ХАМТДАА” уриаг дэвшүүлж, бэлэн

байдлын чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгавруудыг амжилттай гүйцэтгэсэн Барилга, хот байгуулалтын Улсын албаны бэлэн байдлыг ОБЕГ “ХАНГАЛТТАЙ” гэж үнэлүүлсэн.

➤ Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” 3 сарын аяныг өрнүүлж, Улсын хэмжээнд 36 удаагийн үзүүлэх сургалт, 51 удаагийн мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, 1798 аж ахуйн нэгжийн инженер техникийн ажилтнуудыг хамруулав. Хяналт шалгалтын хүрээнд 1015 иргэн аж ахуйн нэгжийн 1072 барилгад шалгалт хийж, 3984 зөрчил илрүүлснээс 3144 зөрчлийг арилгуулж, 66 аж ахуйн нэгжид зөрчлийн хэрэг үүсгэн 76 барилгын үйл ажиллагааг зогсоож, үйлдвэрлэлийн хөнгөн ослыг 28.6 хувиар, хүнд осол гэмтлийг 82.1 хувиар, нас баралтыг 93.3 хувиар бууруулан ажилласан.

➤ “Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 64 барилгын ашиглалт, 345 иргэн, аж ахуй нэгж, байгууллага, 23 сууц өмчлөгчдийн холбооны өмчлөлийн төлөв байдалд 2 сарын хугацаанд хяналт шалгалт явууллаа. Улсын ахлах байцаагчдын гаргасан 27 дүгнэлтийг үндэслэн орон сууцны 2 барилгыг буулгаж, 159 айлын орон сууцны 2 блокийн угсралтыг хийлгэж, 7 ресторан, цайны газрын шингэрүүлсэн хийн баллоныг барилгаас гаргуулж, 3 ресторанд нэмэлт агааржуулалтын систем, 6 аж ахуйн нэгж байгууллагын цахилгааны самбар, тоноглолыг шилжүүлж, газардуулгын холболтыг хийлгүүлэн болзошгүй эрсдэлээс сэргийлж ажилласан байна.

➤ Дархан хотод хоногт 24000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, ашиглалтад оруулсан.

➤ Сүхбаатар аймгийн төв Баруун урт суманд хоногт 3000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан.

➤ “Сэлбэ сэргэлт” төслийг хэрэгжүүлэх хүрээнд Сонсголонгоос Дамбадаржаа хүртэлх чиглэлийн 21.6 км зайд 6 эгнээ бүхий авто машин, нийтийн тээврийн үйлчилгээнд зориулсан замыг 36 том, дунд, жижиг гүүр, 9 туннел, 48.6 км явган хүний зам, 21.6 км унадаг дугуйн зам, 44 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийг байгуулах зураг төслийг боловсруулж дуусгасан.

➤ Хөшигийн хөндийд байгуулах Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний хүрээнд 10,8 км урттай цэвэр ус хангамжийн шугамын угсралт, 15 км урттай 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт, 2,5 км урттай үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

➤ Орхоны хөндийд “Шинэ Хархорум хот байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаан, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж улмаар УИХ-ын 2023.01.19-ний өдрийн 07 дугаар тогтоол гарсан. Үндэсний хорооны 2023.04.15-ны өдөр зохион байгуулагдсан 2-р хурлаар төслийн хүрээнд хийгдсэн ТЭЗҮ хэлэлцэж Шинэ Хархорум хот байгуулах 189363 га газрын байршлын асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлэсэн байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Орон сууцны тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл/-үүдийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулахыг Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газруудад;

2. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 30-50%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах яамны газар, хэлтсийн дарга нарт даалгах.

3. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд, Хөшигийн хөндий, Орхоны хөндийд баригдах шинэ хот, суурин газруудын бүтээн байгуулалт, Сэлбэ сэргэлтийн ажлыг үе шаттай эрчимжүүлж ажиллахыг Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газруудад;

5. Шилэн дансны тухай хуулийн хугацаанд багтаан шаардлага хангасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт;

6. Улсын Их Хурлын 2023 оны 11-р сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбогдон Засгийн газрын тухай хууль, Газрын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт орж Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнээс Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байсан тухайн чиг үүргийг 2024 онд хасаж төлөвлөх.

Барилга, хот байгуулалтын яамны
Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар